

**“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ”
УТҮГ-ЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН
БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.04.16

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны эхний улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Гурав. Үнэлэлт

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **73.1** хувьтай байна.

3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

“ГТХЗНТ” УТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 33 ажил, үйлчилгээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
21	73.1	10	1	-	1	1	3	5

3.2. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				Хугацаа болоогүй
		100	70	30	0	
4	75.0	2	1	1	-	-

3.3. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				Хугацаа болоогүй
		100	70	30	0	
2	100.0	2	-	-	-	-

3.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
				100	90	70	50	30	0		
1	Төсөв, гүйцэтгэл	16	100.0	8	-	-	-	-	-	-	8
2	Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт	6	100.0	6	-	-	-	-	-	-	-
3	Бусад	6	100.0	5	-	-	-	-	-	-	1
Дүн		28	100.0	19	-	-	-	-	-	-	9

3.5. Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжил-тийн дундаж хувь	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Үүнээс /хувиар/					
				100	70	30	0	Хугацаа болоогүй	Хамаа-ралгүй
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	83.7	6	1	-	1	-	2
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	95.0	5	1	-	-	-	-
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	87.9	11	1	2	-	-	1
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	30.0	-	-	1	-	-	1
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	82.5	3	-	1	-	-	9
Дүн		46	85.7	25	3	4	1	-	13

Дөрөв. Дүгнэлт:

I. Төлөвлөлтийн байдал

1. “ГТХЗНТ” УТҮГ 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтот түвшнийг тодорхой төлөвлөлгүй ерөнхий байдлаар төлөвлөснөөс гадна хугацааг улирал бүрээр тодорхойлоогүй байна. Тухайлбал: 1, 4, 7, 28, 32, 33 гэх мэт.

2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төслийн ажлыг Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгахдаа зорилтот түвшнийг ижил төлөвлөжээ. Харин “ГТХЗНТ” УТҮГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө энэхүү арга хэмжээний зорилтот түвшнийг барилгын ажлыг 30 хувьд хүргэнэ гэж 60 хувиар бууруулан төлөвлөсөн байна.

II. Хэрэгжилтийн байдал:

1. “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын газрын үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 86.7 хувь, Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 75.0 хувь, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 100.0 хувь, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 100.0 хувь, нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт 85.7 хувиар тус тус үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **88.9** хувьтай дүгнэгджээ.

2. Галт тэрэгний 2024 оны зуны, 2024-2025 оны өвлийн хөдөлгөөний нэгдсэн зурмагийг баталж, нэгдсэн зурмагийн гүйцэтгэл болон зурмагийн тасалдалд сар бүр дүн шинжилгээ хийж тухай яаманд танилцуулсан. Нэгдсэн зурмагийн гүйцэтгэл 2023 онд 72.8%, тээвэрлэлтийн төлөвлөгөө 92.0%, 2024 оны эхний 12 сарын гүйцэтгэл 81.0%, тээвэрлэлтийн төлөвлөгөө 97.4%-ийн биелэлттэй байна.

3. Төмөр замын тээврийн сүйрэл, осол, гологдлын тоог бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зөвхөн гарсан осол, гологдлын тайлан мэдээг яаманд танилцуулан ажиллаж байгаагаар хэрэгжүүлдэгээс хэтэрдэггүй.

4. Тухайн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын дагуу хөтөлсөн, баримт бичиг хянан шийдвэрлэсэн шийдвэрлэлт зорилтот түвшинд хүрсэн мэт тайлагнаж байгаа хэдий ч тайлант хугацаанд тус төвийн үйл ажиллагаанд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх явцад дээрх үйл ажиллагааг хангалттай хэрэгжүүлж ажилладаггүй болохыг ажлын хэсгийн тайланд дурдсан.

5. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын 5 хэсгийн 46 нээлттэй мэдээллээс “ГТХЗНТ” УТҮГ-т хамаарах 33 арга хэмжээг төрийн байгууллага shilen.gov.mn сайтад тогтмол тайлагнан ажилладаг. Гэсэн хэдий ч мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл, мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээллүүдийг нээлттэй ил тод мэдээлэхдээ жилийн турш хангалтгүй хэрэгжүүлжээ.

6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 11. “ГТХЗНТ” УТҮГ-ын цахим шилжилт, нэгдсэн платформын ажлыг гүйцэтгэх, 12. Төмөр замын тээвэрт цахим гэрчилгээ /RFID/-г нэвтрүүлж, хяналтыг хэрэгжүүлэх, 15. Төмөр замын байгууллагууд тээвэрлэлтийн нэгдсэн

программтай болох гэсэн ажлуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн. Харин 9. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх, 23. Төвийн архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, 27. Шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, сул орон тоог нөхөх, цалин хөлс, нэмэгдэл хөлс, урамшуулал, тусламж, ээлжийн амралт олгох зэрэг хүний нөөцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх гэсэн арга хэмжээг жилийн турш зорилтот түвшинд нь хүргэж ажиллаагүй байна.

Тус төвийн 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:

- Төвийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу хөтлөх,
- Хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй хэрэгжүүлэх боломжтой тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хүний нөөцтэй холбоотой асуудал шийдвэрлэх зэрэг ажлуудыг зорилтот түвшинд хүргэж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний биелэлттэй холбоотой баримт бичгийг хавсралтаар гарган ирүүлж хэвших;
- Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийн хүрээнд ТӨБЗГ-т төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлж, ажилтнуудыг төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтад хамруулах болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдох бэлтгэл ажлыг яамнаас өгсөн чиглэлийн дагуу бүрэн хангах;

2. Хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, төмөр замын тээврийн салбарын олон улсын хурал зөвлөгөөнд санал дэвшүүлэх, оролцох, асуудал шийдвэрлүүлэх, хүний нөөцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, хуулийн хугацаанд албан бичгийн хариуг хүргүүлэх зэрэг ажлуудыг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний биелэлттэй холбоотой баримт бичгийг хавсралтаар гарган ирүүлж хэвших;

3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах;

4. Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгавар болон “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг бүрэн хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлэх;

5. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан үр дүн муутай, ялангуяа он дамжин хэрэгжилт удааширч байгаа арга хэмжээнүүдийн биелэлтийг сайжруулж бүрэн хэрэгжүүлэх. Үүнд:

- 11. “ГТХЗНТ” УТҮГ-ын цахим шилжилт, нэгдсэн платформын ажлыг гүйцэтгэх,
- 12. Төмөр замын тээвэрт цахим гэрчилгээ /RFID/-г нэвтрүүлж, хяналтыг хэрэгжүүлэх,
- 15. Төмөр замын байгууллагууд тээвэрлэлтийн нэгдсэн программтай болох,
- 30. Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах.

6. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР